ТҮҮХ, СОЁЛ

М. Зэнээ

ӨВӨР МОНГОЛЫН ХУВЬСГАЛТ АГУУЛГАТАЙ АРДЫН ДУУНЫ ТУХАЙ

Ангит нийгмийн түүхийн аль ч үеийг авч үзсэн аливаа улс оронд гадаад дотоодын дарлал, мөлжлөгийн эсрэг ард түмэн эрс шийдвэртэй олон хэлбэрээр тэмцэж ирсэн байдаг. Тэмцлийн энэ олон хэлбэрээс түгээмэл дэлгэрсэн нэг арга бол ардын аман зохиол, түүний нэг төрөл ардын дууг ашиглан эсэргүүцлээ илэрхийлэх явдал байв. Гадаад, дотоодын дарлан мөлжигчдийн эсрэг явуулсан ард түмний шударга тэмцэл тэр бүр амжилтанд хүрч чадахгүй байсан учраас тэд ардын дууны өвөрмөц аргыг сонгон авч аливаа дарлагчдыг эсэргүүцэн, олон түмнийг тэмцэлд уриалж, ардын баатруудын жишээг хойч үедээ үлдээж, тэднийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхийг эрхэм болгож иржээ. Үзэл суртлын тэмцлийн энэхүү арга дарлагдагч олон түмний хүсэл мөрөөдөл, ертөнцийг үзэх үзэл хийгээд харийн түрэмгийлэгчид, мөлжигч ангийн эсрэг явуулсан ардын шудрага тэмцлийг тэр дор нь тольдон тусгахад аман зохиолын бусад төрлөөс хамгийн дөхөм, хамгийн түгээмэл хэлбэр нь болох ардын дуугаар голчлон илэрдэг байв. Эртнээс Төв Азид нүүдэллэн амьдарч ирсэн монгол угсаатны нэг хэсэг Өвөр Монголын ард түмний аман зохиол бусад монголчуудын адил ардын дууны баян сантай. Харийн болоод нийгмийн дарлалыг эсэргүүцсэн ард түмний тэмцэл эрх чөлөө, аз жаргалаа тэмцэн олох гэсэн олон түмний эх оронч хөдөлгөөнийг тусгасан Өвөр Монголын ардын дууны эрдэнэсийн сангаас эдүгээ хүртэл уламжлагдан ирсэн нь цөөнгүй билээ.

XVII зууны 30-аад оноос Манжийн ноёрхол, Хятадын шунахай худалдаачид, баяд, ноёд, цэргийн харгис этгээдүүдийн давхар дарлалд хэлмэгдэж ирсэн Өвөр Монголын ард түмэн нийт монгол даяар өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911/1912 онд Манжийн ноёрхлоос ангижран салсан боловч түүний дараа байгуулагдсан Дундад Иргэн Улс (1912— 1927 он)-ын үеийн цэргийн харгис эрхтнүүд болон 1927 онд хувьсгалын эсэргүү эргэлтээр засгийн эрхийг авсан Чан Кай-шийн ноёрхлын үе (1927— 1949), тэрчлэн японы милитаристуудын эзлэлтийг (1931—1945) ээлж дараалан амсаж түүнийг байнга эсэргүүцсээр иржээ. Өвөр монголын ард түмэн гадаадын эзэрхэг түрэмгийчүүдийн эсрэг ийнхүү тэмцэхийн зэрэгцээ тэдний гар хөл болж байсан дотоодын феодалуудыг мөн нэгэн адил эсэргүүцэн тэмцсээр байжээ.

Гадаад дотоодын дарлагчдыг эсэргүүцсэн Өвөр Монголын ард түмний үндсэний эрх чөлөөний олон үеийн тэмцэл зохион байгуулалттай, хатуужилтай болж цаашид улам өрнөн амжилтанд хүрэхэд нь 1917 онд Орос оронд ялсан Октябрийн социалист их хувьсгал, 1921 онд Монгол оронд ялсан ардын хувьсгал болон Японы милитаристуудын эсрэг Зөвлөлт-монголын армиас 1945 онд хийсэн чөлөөлөх шудрага дайн онцгой нөлөө үзүүлсэн юм.

Хөрш зэргэлдээ Монгол, Зөвлөлтийн ард түмний хувьсгалч ялалтын дайчин жишээгээр Өвөр Монголын ард түмэн үндэсний эрх чөлөөнийхөө

төлөө баатарлагаар тэмцсэний үр дүнд 1947 оны 5-р сарын 1-нд Өвөр Монголын автономит районыг (ӨМАР) анх байгуулжээ.

ӨМАР байгуулагдсан нь эхний үед нийт хүн амын өргөн давхаргааны хувьсгалч ухамсрыг урьд хожид үзэгдээгүй ихээр сэргээгээд зогссонгүй улс орноо хөгжүүлэх, соёл боловсролоо дээшлүүлэх, эдийн засгийн талаар бие даан улс төрийн эрхийг олоход чухал шижим болжээ. ӨМАР байгуулагдсаны дараахь арваад жилд тус орны дэвшилт сэхээтнүүдийн идэвх чармайлтаар соёлын байгууллагын хувьд олон шинэ зүйл хийгдэж байснаас зөвхөн ардын аман зохиолын талаар цөөн жишээ авч үзье. 1950, 60-аад оны хооронд Өвөр Монголд «Монгол ардын дууны түүвэр»[1], «Цахар ардын дуунууд»[2], «Ардын аман зохиолын түүвэр»[3], «Зүүн орны ардын дуунууд»[4], «Синьцзяны монгол ардын дуунууд»[5], «Өвөр Монголын өөртөө засах орны утга зохиолын түүх»[6] зэрэг олон арван эмхтгэлүүд гарч байсан юм. Эдгээр эмхтгэлүүдэд Өвөр Монголын ард түмний туулж өнгө-рөөсөн түүхэн үеүдэд холбогдолтой эрх чөлөөний тэмцлийн тусгал болсон ардын дууны зарим нь нийтлэгдэж байсан байна. ӨМАР байгуулагдсаны эхний үед хийгдэж байсан энэ мэт дэвшилтэт алхамууд аажмаар Маогийнхны хятадчилан уусгах бодлогод хэлмэгдэн тэдний шууд хяналтанд орсон нь Хятадын Коммунист намын (ХКН) дотор зонхилох болсон Мао Цзэдун тэргүүтэй харгис бүлгийн хятад бус үндэстний талаар талаар баримталж байсан хүчээр уусгах бодлоготой шууд холбоотой юм.

Ардын аман зохиолыг цуглуулах, эмхтгэх, хэвлэн нийтлэх ажил Өвөр Монголд хийгдэж байсан тэр үед ард түмний дунд өргөн дэлгэрсэн зарим дуунуудыг үл нийтлэх, засварлах, тэр ч байтугай хэвлэхийг хориглох хүртэл арга хэрэглэдэг болжээ. Тухайлбал, Өвөр Монголын ард түмний дунд 1947 оны үед дуулах болсон «Таван сарын шинийн нэгэн»[7] гэдэг дууны нэгдүгээр бадгийн 3-р мөрт:

«...тэргүүлж байх хувьсгалчдын» гэхийг

«..тэргүүлж байх Улаанхүүгийн» хэмээн өөрчилсөн баримт байна.

Түүнчлэн «Данаабал»[8], «Алгирмаа»[9], «Тогтохын дуу»[10], «Гаадаа мээрэн»[11] зэрэг дуунаас ард түмний эрх ашгийг хамгаалсан буюу тэмцлийн чанартай дайчин үгүүдийг нь өөрчлөн зассанаас гадна «Өвөр Монголын улаан туг»[12], «Дотоод Монголыг мандуулах дуу»[13], «Олон бага залуучууд»[14], «Шинэ ламын дуу»[15], «Хувьсгалт нам»[16] зэрэг хувьсгалын сэдэвтэй дуунуудыг дээр дурдсан аман зохиолын түүвэр, дууны эмхтгэлүүдэд огт оруулалгүй хассан байна.

Харийн түрэмгийлэгчид болоод дотоодын харгис хүчний эсрэг үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн өвөр Монголын ард түмний үзэл санааны бодит тусгал болсон ардын дууг сурвалжлан олж ту-

1. «Монгол ардын дууны түүвэр», Өвөр Монголын өдрийн сонины хэвлэл 1949,
2. «Цахар ардын дуунууд», Хөх хот, 1959
3. «Ардын аман зохиолын түүвэр» № 1, Хөх хот, 1958.
4. «Өвөр Монголын зүүн орны ардын дуунууд», Хөх хот, 1959.
5. «Синьцзяны монгол ардын дуу шүлгүүд», Хөх хот, 1959.
6. «Өвөр Монголын өөртөө засах орны утга зохиолын түүх», Хөх хот 1962.
7. «Ардын аман зохиолын түүвэр», № 1. Хөх хот ,1958, 11-р тал
8. ДДСХ-гийн гар бичмэлийн сан».
9. Э. Оюун. «Монгол ардын харилцаа дууны зүйлээс » УБ., 1960, 26-р тал.
10 «Монгол хэл зохиол, түүх» No 2, Хөх хот, 1960, 37-р тал.
11 ДДСХ-гийн гар бичмэлийн сан,
12. «Дотоод Монголын ардын сэтгүүл» 1925, № 1, 3-р тал
13. «Монгол хэл, зохиол, түүх», No 9. Хөх хот, 1960.
14. ДДСХ-гийн гар бичмэлийн сан.
15. ДДСХ-гийн гар бичмэлийн сан.
16. «Монгол түүх, хэл бичиг», № 12, Хөх хот, 1958. 89-р тал.

хайн үйл явдалтай нь харьцуулан судлах нь эл ард түмний зарим түүхэн үйл явдлыг тодруулахад хэрэглэгдэхүүн болох төдийгүй, эрх чөлөөний тэмцлийн баялаг уламжлалыг нь илтгэн харуулах ач холбогдолтой юм.

Ийм ч учраас пролетарийн их зохиолч М. Горький «Ардын аман зохиолыг мэдэхгүйгээр хөдөлмөрчин ард түмний түүхийг мэдэж болохгүй»[17] гэж ардын аман зохиолын ач холбогдлыг өндөр үнэлсэн байдаг.

Өвөр Монголын эрх чөлөөний сэдэвтэй ардын дууг тэр үеийн бодит нөхцөл, түүхэн үйл явдалтай нь харьцуулан судлах замаар

а. Харийн түрэмгийллийг эсэргүүцсэн;

б. Нийгмийн дарлалыг эсэргүүцсэн

в. Хувьсгалын сэдэвтэй хэмээн гурван үндсэн хэсэгт хуваан үзлээ.

Харийн түрэмгийллийг эсэргүүцсэн дуунд Манжийн ноёрхол, Японы милитаристуудын эзлэлт, Хятадын харгис гоминданы түрэмгийллийг эсэргүүцсэн түүхэн сэдэвтэй дуунууд орох юм.

Эдгээрийг он дараалын дагуу өгүүлбэл:

XVII зууны эхэнд Өвөр Монгол нь монголын бусад хэсгээс эн түрүүнд манжийн байлдан дагуулагчдад эзлэгдсэн юм. Манжийн ноёрхолд байсан 200 гаруй жилийн (1636--1912) хугацаанд Өвөр Монголын ард түмэн номхон хүлцэнгүй дарлагдан суусангүй. Бололцоотой үе бүрт эрх чөлөөнийхөө төлөө тэмцдэг байв. Хугацаагүй цэргийн алба хаах, феодал ноёдод унаа залгуулж, шүүс бэлдэх, өртөөний албанд дайчлагдах зэрэг олон албыг янз бүрийн хэлбэрээр эсэргүүцэж байсан бөгөөд тэр бүхнийг тусгасан «Алгирмаа». «Данаабал», «Өвөрлөгөөтэй бичиг»[18], «Алтан сан»[19], «Чжин чжоу хотын есөн толь»[20] зэрэг олон дуу гарчээ.

Тухайн үеийн нийгмийн хүнд хэцүү бүхнийг нуруундаа үүрч байсан ард түмний зовлонт амьдралын байдлыг хугацаагүй цэргийн албанд явсан эр нөхрөө хүлээж буй эмэгтэй хүний гунигийн аясаар илэрхийлсэн «Алгирмаа» гэдэг дууг монголчуудын дунд мэдэхгүй хүн бараг үгүй гэж хэлж болно. Уул дууны гол баатар болох хүмүүс одоогийн Жирэмийн чуулганы Хорчин баруун гарын дундат хошууных байсан бөгөөд тэр хошууг Түшээт вангийн хошуу гэдэг байжээ.

«Данаабал» гэдэг харилцаа дууны гол баатар Данаабал мөн л хугацаагүй цэргийн албанд дайчлагдан нухлагдсан тэр үеийн нэгэн цэрэг эр юм. Данаабал өнгөрсөн зууны эцэс, XX зууны эхээр амьдарч байсан түүхт хүн бөгөөд тэрээр манжийн үеийн хугацаагүй цэргийн албыг эсэргүүцэн эх нутагтаа амгалан тайван аж төрөн амьдрахын төлөө манжийн цэргийн харгис эрхтэн Өвөр Монголын феодал ангийн төлөөлөгч Эрдэнэ билэгийг эсэргүүцэн боссон байна. Эрдэнэбилэг буюу Бао Цзин-юй морь, буунд чадамгай, ойр хавийн хошуу нутагтаа алдаршсан залуу хүү Данаа балыг өөрийн цэрэгт дайчилж «мэргэн буучийн» үүргийг гүйцэтгүүлж байжээ. Эрдэнэбилэг бол XIX зууны эцэс XX зууны эхээр Манж чин гүрний цэрэгт дээгүүр тушаалтай байсан цэргийн харгис эрхтэн байв. Данаабал цэрэгт явахаасаа өмнө нутгийн хүүхэн Цзинсянтай (Жиншаан) хайр сэтгэлтэй болсон боловч тэр үеийн нийгмийн бурангуй ёсноос, болж тэд амьдралаа холбож чадсангүй. Данаабал цэрэгт 10-аад жил алба хаагаад эх нутаг, эцэг эх, амраг ханиа мөрөөдөн нутагтаа буцах чөлөөг Эрдэнэбилэгээс гуйжээ. Эрдэнэбилэг чөлөө өгөөгүй тул тэр бослого гаргасан

17. М. Горький, Собрание сочинений в 30-ти томах, т. 27, Гослит издат, 1953 с. 311.

18. м. Гаадамба, Д. Цэрэнсодном «Монгол ардын аман зохиолын дээж бичиг», УБ, 1967. 42-р тал

19. «Цахар ардын дуунууд», Хөх хот, 1959, 64-р тал

20. «Цахар ардын дуунууд», Хөх хот, 59-р тал

байна. Эрдэнэбилэг Данаабалыг эд мөнгө, хэргэм зэргээр буюу эс чадвал хүчээр цэргийн хороондоо байлгахыг оролдсон боловч эх нутагтаа очиж, амгалан тайван аж төрөн, аз жаргалтай амьдрах гэсэн түүний эрс зоригийг мохоож чадсангүй. Уг дуунд Данаабалын цэргээс оргож байгаа байдлыг

«...Албаны ах дүү нар гүйгээд гүйцээд ирвэл

Агт хүлэг гунан ухаагийн минь гүйдэл мэдэг

Албаны тэргүүн Эрдэнэбилэг гүйцээд хүрээд ирвэл

Арав дуугарах сэлээдийн минь оноо нь мэдэг» хэмээн дүрслэсэн нь гадаадын эзэрхэг түрэмгийчүүд болон тэдний гар хөл болж байсан дотоодын цэргийн харгис эрхтнүүдтэй эцсээ хүртэл тэмцэх гэсэн ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл болжээ.

Данаабал цэргээс оргоод өсч төрсөн нутаг Өндөр шилийн айл (Өвөр Монголын Жирэм аймгийн Бао вангийн хошуу)-даа буцаж очжээ. Харгис засгийг бататган хамгаалах, феодалын цэрэгт алба хаах явдлаас татгалзсан зоригт хүү Данаабал түүний сэтгэлт бүсгүй Цзиньсян хоёроор гол баатар хийсэн яруу сайхан түүхэн харилцаа дууг Хорчины ард түмэн ийнхүү зохион дуулж байсан нь эдүгээ хүртэл уламжлан иржээ.

Манжийн ноёрхлыг эсэргүүцсэн ХХ зууны эхэн үеийн нэгэн томоохон үйл явдал бол малын бэлчээрийг хятад газрын эзэд, колоничлогчидод худалдахын эсрэг манж-Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчид болон дотоодын феодалын эсрэг чиглэгдсэн ард түмний тэмцэл байлаа. Уул үйл явдлын эхэн үеийн байдлыг тусгасан «Даагын хуа»[21] хэмээх нэгэн дуунд:

«Давуу сайхан нутаг

Даагын хуагий минь

Дархан хошуу Да ноён[22]

Даеэ нээр[23] солиод уучихсан юм шүү» гэж нутаг бэлчээрээ худалдсан мунхаг ноёдыг эсэргүүцэн ард түмэн дуулсан байдаг.

1899—1900-гаад оны үед Манж Чин гүрний бараг бүх нутагт газар нутгаа хамгаалж харийн түрэмгийлэгчид болон нутгийн феодалын шунахай явдлыг эсэргүүцсэн бослого хөдөлгөөн өрнөж байсан байна. ХХ зууны эхэн үед гадаадын колоничлогчдод газар билчээрээ найр тавин худалдах явдал Өвөр Монголд нилээд газар авсан байна. Энэ явдлаас болж Өвөр Монгол дахь ангийн тэмцэл нь харийн түрэмгийллийг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний тэмцэлтэй нэгдэж эхлэсэн байна. Ийм хөдөлгөөний нэг жишээ бол жирэмийн чуулганы Горлосын өмнөт хошууны харъяат Тогтох тайжийн удирдсан бослого юм. Өвөр Монголын Жирэмийн чуулганы Горлосын өмнөт хошууны Тогтох (1863—1922) тайж 1901 оны өвлөөс нутгийн ард иргэдийн амгалан тайван байдлыг хангахын тулд хятадын колоничлогчдод бэлчээр нутгийг худалдсан харгис феодалуудын эсрэг тэмцэж эхэлжээ. Тус хошууны засаг Чимидсампил[24] харъяат хошууны нутгаа Хятадын колоничлогчдод худалдаж дуусан тул малчин монголчууд бэлчээр нутаггүй хавчигдахад хүрчээ. Иймээс Тогтох 1906 оноос хойш Өвөр Монголын ноёд, Манжийн эрх баригчидтай хуйвалдан бэлчээр нутгийг хятадын колоничлогчдод худалдахыг эсэргүүцэн зэвсэг барин тэмцэж Чин улсын цэргийг удаа дараагаар няцааж байв. Тэд шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, өрийн данс бичгийг шатааж, олзолсон эд мөнгө хөрөнгийг нутгийн ядуу монголчуудад түгээн өгч байлаа. Тогтохын удирдсан ардын зэвсэгт бослого нь нийт монгол даяар цуу-

21 ДДСХ-гийн гар бичмэлийн сан.

22. Дан ноён (Дархан хошууны ноён, солиот дархан ван) хочтой хүн байв.

23. Даеэ-Хар тамхи гэсэн хятад үг

24. Д. Наваннамжил. Зоригт баатар Тогтохын товч намтар. УБ. 1946. 25-р тал

райтаж дөрвөн жил гаруй хугацаанд Чин улсын цэрэгтэй 100 гаруй удаа[25] баатарлагаар тулалдахдаа ард олонтой нягт холбоотой байсан учир тэдний дэмжлэг тусламжийг байнга авч байжээ. Энэ тэмцлийг магтан сайшаасан ардын дуу Өвөр Монголд олон байдаг. Түүний нэгэнд:

«Агт морио унаад гарахдаа Тогтох
Алт мөнгө, олз ашгийг бодсонгүй ээ хө
Ар Өвөр хошуу нутгаа хамгаалахын төлөө
Арван зургаан яаманд хүрсэн дээрэм нэртэй болов хө» гэсэн нь Тогтохын монгол угсаатнаа нэгтгэж газар шороогоо хамгаалах гэсэн эх оронч сэтгэлийг илэрхийлсэн байна. Босогчид дайсны эсрэг тэмцэхдээ ард түмнийхээ хүчийг ямагт түшиглэж байсныг:

«Алс газрын ах дүү нар нь
Анд Тогтохынхоо бичгийг олоод
Аадал гэрээсээ салан хагацаж
Арван тавандаа цугларав хө» хэмээн илэрхийлжээ. Тогтохын удирдсан бослого орон нутгийн феодалын эсрэг эхлэснээ сүүлдээ манж, Хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгч, газар түрээслэгчдийн эсрэг улам өрнөн ангийн тэмцлээс үндэсний тэмцэлд шилжин орсон байна. Уул бослого үргэлжилсээр 1910 оны үед Тогтох манж-хятадын харгис цэрэгт шахагдан улмаар дайсны давуу хүчний эсрэг тулалдах бололцоогүй болж Баргаар дамжин Ар Монголын Цэцэн хан аймагт гарчээ. Энэ үйл явдлыг тусган уул дуунд:

«...дайсны хүч ихэдсэнийг
Тогтох баатар үзэж гарав хө
Хувийн нөхөдтэйгээ зөвлөж байгаад
Халх монгол руу оров хө» гэж бодитой түүхэн үнэнийг уран сайхны аргаар тун чадварлаг дүрслэжээ. Тогтохын удирдсан энэхүү тэмцэл нь Өвөр Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн улам хүчтэй өрнөхөд шинэ уриа болжээ.[26]

Манжийн ноёрхлын эсрэг гарч байсан ард түмний тэмцлийн бас нэг өвөрмөц хэлбэр бол «дугуйлан» байлаа. Феодалын дарлал, харийн түрэмгийллийг эсэргүүцэх үзэл санаа бүхий хүмүүс аглаг газар дугуйран суугаад өөрсдийн бодол санаа, хошуу нутгийн байдал, дарлал мөлжлөгийн хүнд хэцүүг харилцан ярилцаж шүүмжлэн хэлэлцээд харийн ба нийгмийн дарлал мөлжлөгийн эсрэг хэрхэн тэмцэх арга хэлбэрээ тогтоодог байжээ. Тэд өөрсдийн гаргасан шийдвэр, хошуу тамгын газар буюу чуулганд өргөх гомдол, заргын бичиг тэргүүтэнд гарын үсгээ дугуйруулан зурдаг байв. Энэ нь оролцогчид тэгш эрхтэй, хэн удирдаж буй нь нууц, ардчилсан шинжтэй байжээ. Өвөр Монголд ийм хөдөлгөөн анх Их Зуугийн чуулганы ордос нутгийн Үшин хошууны монголчуудын дунд 1858 онд гарч, дараа нь 1866 онд Отог хошуунд дэлгэрсэн[27] байна. Тэр үеийн дугуйлангийн хөдөлгөөнтэй холбогдон гарсан «Эсийн тэмцэл»[28] гэдэг ардын дуунд:

«Үшин хошууны үлгэр
Үргэлжлэн самууран байна.
Үйл зовлон ардад бий
Үнэн жаргал ноёдод байна.

25. Эдүн хишиг. Зоригт баатар Тогтохын намтрын тухай, шүүмж, «Монгол түүх, хэл бичиг», № 17, Хөх хот, 1958, 18-р тал.
26. БНМАУ-ын түүх, II боть, 409-р тал.
27. Маоизм Маогийнхан, УБ, 1974, 143-р тал.
28. «Монгол хэл зохиол, түүх», Хөх хот, 1960, № 1. 54-р тал.

Аяа энэ жихүүн цагт
Ачлал элбэрэл гэж
Анхааралгүйгээр

Эцсийн тэмцлийг явуулцгаая даа» хэмээн нийгмийн ба харийн дарлалыг эсэргүүцсэн санаа зоригоо ард түмэн илэрхийлэхийн сацуу тэдний эсрэг нэгдэн тэмцэхийг олон түмэнд уриалсан байдаг. Нийт Монгол угсаатны ард түмний олон зуун жилийн тэмцэл эцсийн эцэст ялалтаар төгсч манжийн дарангуйлагчдыг 1911—1912 онд нутаг орноосоо хөөн зайлуулсан бөгөөд энэ тухай ардын дуу нилээд байдгаас жишээ болгон «Амбан гуай»[29] гэдэг дууг авч үзье.

Өргөн замыг таглаад байдаг
Өндөр ханзат байшин хайчив даа
Өргөн түмнийг жанжлаад байдаг
Өнөө жанжингууд өнгөрсөн биз дээ
Үдэш болгон шатаад байдаг
Өмхий дэн нь унтраа биз дээ
Үрийн үрд жанжлаад байдаг
Өнөөх амбан нь талийгаа биз дээ» гэж хэдэн зуун жил ард түмний хүсэн хүлээсэн өдөр ирснийг бахдан бахархасан өнгө аяс дээр хэзээ нэгэн цагт харийн дарангуйллын дэглэм унах тавилантай гэсэн санааг гарган үзүүлжээ.

Манжийн ноёрхлын үе дэх монгол ардын түүхэн дуу харийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцлийн хүчит зэвсэг болсон онцлогтой юм. Манжийн ноёрхлыг эсэргүүцсэн тэмцлээ ардын дуунд ийнхүү тусгахын зэрэгцээ 1912 оноос 1949 он хүртэл үргэлжилсэн хятадын мөнгө хүүлэгч, шунахай худалдаачид болон Чан Кай-шийгийн харгис гоминьданы түрэмгийллийн эсрэг хятадын ард түмний нэгэн адил Өвөр Монголын ард түмэн үндэс нийхээ эрх чөлөөний төлөө тэмцэж байсан явдал энэ үеийн томоохон үйл явдлыг нэг юм. Хятадын харгис гоминьданы эсрэг тэмцлийг харуулсан «Тяньхүү»[30], «Гаадаа мээрэн», «Хүчит цэрэг»[31], «Бинтү-ван»[32], «Гоминьданыг эсэргүүцсэн дуу»[33], «Хатан гол»[34], «Саарал илжиг»[35] зэрэг олон арван дуу зохиогдон ард түмний ам дамжин дуулагдсаар эдүгээ хүрч иржээ.

Энэ үеийн дуунд Гаадаа мээрэний тухай дуу томоохон байр эзлэнэ. Жирэмийн чуулганы Дархан хошууны Гаадаа мээрэн хятадын колоничлогчдод ардын малын бэлчээрийг худалдсан хошуу ноёныхоо эсрэг эхлэн тэмцээд тэр нь бослого болон өрнөснийг уг дуунд бүрэн тусгасан байдаг. Хятадын цэргийн харгис эрхтэн Чжан Цзо-лингийн хүү Чжан Сюе-лянд хахууль өгч, хятад гүнжтэй гэрлэн худ ураг болсон хошуу ноён ван Намжилцэрэнгээс таадаа мээрэн заргалдсан заргаа авч чадалгүй баривчлагдан шоронд хоригдсоноор уул үйл явдал өрнөдөг. Гаадаа мээрэнг түүний эхнэр Мудан нь нөхдийнх нь туслалцаатай шоронгоос чөлөөлж хятадын ноёрхлын эсрэг эцсээ хүртэл тэмцэх тангараг эр эм хоёр тавьснаар бослого улам ширүүссэн байна.

«Хайртай нутаг Дархан хошуугаа
Хайрлаж явсан Гаадаа мээрэн

29. «Монгол хэл зохиол», No 6, Хөх хот, 1955, 46-р тал
30. Э. Оюун. «Монгол ардын харилцаа дууны зүйлээс» УБ., 1960, 37-р тал
31. «Монгол ардын дуу»-Өвөр монголын өдрийн сонины хэвлэл, 1949. 14-р тал
32. «Монгол ардын дуу»-Өвөр Монголын өдрийн сонины хэвлэл, 1949. 24-р тал
33. ДДСХ-гийн гар бичмэлийн сан
34. ДДСХ-гийн гар бичмэлийн сан
35. «Монгол ардын дуу», Хөх хот, Өвөр Монголын өдрийн сонины хэвлэл, 1949, 335-р тал

Хамгаас сайхан Шивэрт нутгаа
Хятадад өгөх арга байна уу
Өссөн нутаг Шивэртээ
Өшөөт хятад дайсанд булаагдвал
Өвөг дээдсийн алтан шарилыг
Оршуулах газар хаана байна» гэж өссөн төрсөн нутгаа нүдний цөцгий мэт хамгаалагч эх оронч эрсийн сэтгэлийн хүчийг Гаадаа мээрнээр төлөөлүүлж уг дуунд илэрхийлсэн байна. Дархан хошууны нутаг Шивэрт гэдэг газрыг хятадын шунахай худалдаачдад өгсөн ван Намжилцэрэнгийн эсрэг 1929 онд гарсан энэ бослого 1930 он гэхэд 500 гаруй цэрэгтэй болоод байв.[36] Тэд жил гаруй нутаг орноо халдлага түрэмгийллээс хамгаалж байгаад 1931 оны хавар дайсны давуу хүчинд арга буюу ялагджээ. Гаадаа мээрэнгийн тухай дуу, бүхэл бүтэн хөгжмийн зохиол, ший жүжиг хүртэл хятадын урлагийн тайзан дээр удаа дараа тавигдаж байсныг бид санаж байна.

Тогтох тайж, Гаадаа мээрэн нарын удирдсан бослого хоёул эх нутаг, газар шороо, хүн ардынхаа сайн сайхан байдлын төлөө дотоод, гадаадын дарлалыг эсэргүүцсэн шинж чанартай байсан боловч зохион байгуулалт хэмжээ далайц, эцсийн зорилгын хувьд ялгаатай байсан юм. Тогтохын удирдсан бослого нийт монгол угсаатнаа хамарч, тэднийг нэгтгэн тусгаарлах зорилготой байсан бол Гаадаа мээрэнгийн удирдсан бослого хошууны ардыг хамарсан, орон нутгийн шинж чанартай байжээ. Иймээс Тогтохын бослого одоогийн хятадын удирдах бүлгийн үзэж байгаагаар Хятадын олон үндэстний их гэр бүлийн нэгдлийг хагалан бутаргах» чиглэлд баг таж, харин Гаадаа мээрэнгийн бослого нь «Өвөр Монголчуудыг талдаа татах гэсэн тэдний оролдлогод» илүү нийцтэй ашиглагдах үндэс болсон байна. Өссөн төрсөн нутаг, газар шороо, хүн ардынхаа төлөө амь хайргүй тэмцэж явсан баатарлаг эрсийн дууриалалт мянга мянган жишээний нийтлэг дүр болсон Тогтох, Гаадаа нарын тухай дуу нийт Монгол даяар ийнхүү ам дамжин тархсан нь мэдээж боловч сүүлийн үед зөвхөн «Гаадаа мээрэний» тухай дуу, жүжгийг хятадын урлагийн тайзан дээр онцлон тавих болсон нь дээр дурдсан «Өвөр монголчуудыг талдаа татах гэсэн оролдлоготой» нь холбоотой юм. Үндэсний эрхийн төлөө явуулсан энэ хоёр тэмцлээс Гаадаа мээрэнгийн тэмцлийг ийнхүү онцлон үзэх болсон нь хятад дахь дото дын ангийн тэмцлээр халхавч хийж, их хан үндэстний эсрэг тэмцэж байсан хятад биш үндэстний тэмцлийг үгүйсгэдэг Маогийн үндэсний бодлогын мөн чанарын тод илрэл болно. ««Гоминьданыг эсэргүүцсэн дуу» хэмээх өөр нэг дуунд:

«Үнэсэн овоогоо өндөр болго.
Үнэн Монгол гэж таньж авъя!
Үхэл болгогч гоминьданыг
Үнэсэн товрог болгоё!
...Хар тамхи бүү тат!
Хар хятадтай[37] бүү нийл!
Хар Хятадтай нийлбэл
Хамаг зовлон амсана!» гэсэн байдаг.

Дууны үгийн утга санааг задлан үзэхэд Чан Кай-шигийн гоминьданы харгислалын эсрэг тэмцэлд ард түмнийг уриалан дуудсан, тэднийг үзэн ядсан байдал нэг талаас харагдах боловч нөгөө талаас Чан Кай-шийн хүчээр хятадчилах бодлого нь цөөнх үндэстний ард түмний дотор үндэсний

36. Эдүнхишиг. Гаадаа мэрэнгийн бослогын тухай өгүүлэл-«Монгол хэл зохиол, түүх», Хөх хот, 1960. № 1. 58—60-р тал
37. Чан Кай-шийн харгис гоминьданыг хэлсэн бололтой.

үзэл ухамсарыг сэргээж байсныг илчилж байна. Дээрх жишээнүүдээс авч үзвэл Чан Кай-шийн харгис гоминьданы түрэмгийллийн эсрэг Өвөр Монголын ард түмний тэмцэл хүчтэй өрнөөд зогссонгүй, тэр нь ардын дуунд ихээхэн хэмжээгээр тусч байсан нь тодорхой байна.

Тэрчлэн 1930-аад оноос 1945 он хүртэл Хятадын зүүн хойт районы гурван муж болон Өвөр Монголын зүүн хэсэгт үүрлэж байсан Японы булаан эзлэгчдийн эсрэг «Японыг эсэргүүцсэн нь»[38] «Найман туургын га дууг зохион дуулж байжээ. Японы булаан эзлэгчдийн эсрэг зохиогдзуур (гадуур)»[39] «Онгон булт»[40], «Хянган морьт цэрэг»[41], зэрэг олон сон эдгээр дуу харийн түрэмгийлэгчдийг үзэн ядсан, түүний эсрэг баатарлагаар тэмцэхийг уриалсан эх оронч үзэл санаагаар дүүрэн байдаг. «Японыг эсэргүүцсэн нь» гэдэг дуунд:

«...Агаарын нарыг халхлах нь хө
Алтан цагаан үүл дээ хө
Аав ээжээс салгах нь хө
Атаатан япон шулмууд хө» гэж дайсныг жигшин зэвүүцсэн санаагаа ард түмэн илэрхийлжээ. Өвөр Монголд 1940-өөд оны үед улам хүчтэй өрнөх болсон Японы эзлэлтийг эсэргүүцсэн тэмцэл өдөр бүр өргөжин тэлсээр улмаар хувьсгалт хэргийн эхлэлд тулж очсоныг «Хянган морь цэрэг» дуунд.;

«Хорт муу Наран улс хө
Ховдог санаа хэтрэв хө
Хойт захын улсаас хө
Хувьсгалын хэрэг эхлэв хө» хэмээн дүрслэжээ. Дууны үгийн утга санааг авч үзвэл Японы эзлэлтийг эсэргүүцсэн тэмцэл Өвөр Монголд хүчтэй өрнөж байсныг батлахын зэрэгцээ 1917 онд Орос оронд ялсан Октябрийн социалист хувьсгал, 1921 онд Монголд ялсан ардын хувьсгалын чөлөөлөх үзэл санааны нөлөөлөх ач холбогдлыг өндөр үнэлж байсныг давхар гэрчилж байна. Өвөр Монголын ард түмэн олон зууны турш өөрийн оронд ноёрхож байсан харийн түрэмгийлэгчид болох Манжийн ноёрхол, Хятадын худалдаачид мөнгө хүүлэгч, цэргийн харгис эрхтнүүд болоод японы милитаристуудын эсрэг байнга тэмцэж байсан нь дээрх бүх жишээгээр батлагдахын гадна тэр нь ардын аман зохиолын нэгэн төрөл дуунд ийнхүү тусгалаа олж эдүгээ хүртэл хадгалагдан иржээ. Харийн дарлалыг эсэргүүцсэн энэ мэт тэмцлийн зэрэгцээ тэдний гар хөл болж байсан хар, шар феодалуудын эсрэг тэмцэл ч Өвөр Монголд өрнөж байсан юм.

«Эдүгээ хүртлэх бүх нийгмийн түүх бол ангийн тэмцлийн түүх мөн»[42] гэж К. Маркс тодорхойлсон байдаг нь ангиудын хоорондох туйлын зөрчлийг харуулсан жинхэнэ бодит дүгнэлт юм. XI—XX зууны эх хүртэлх Өвөр Монголын нийгмийн үндсэн ангиуд нь феодал, ард хэмээх хоёр үндсэн хэсэгт хуваагдаж байсан бөгөөд тэд хоорондоо үргэлжийн тэмцэлтэй байсан байна. Тэдний хоорондох ангийн тэмцлийн хэлбэр нь янз бүр байсны дотроос харьяат ноёноосоо нүүн зайлах, алба гувчуур төлөхөөс татгалзах, авилгач шунахай ноёдтой заалдах явдал зонхилж байжээ. Харийн түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн ардын дууны өмнө өгүүлсэн жишээнүүд ч нэг талаар гадаадын эзэрхэгчүүдийн эсрэг тэмцсэн шинж чанар-

38. «Өвөр Монголын зүүн орны ардын дуунууд», Хөх хот, 1959. 5—7-р тал
39. Г. Ринчинсамбуу. «Монгол ардын дууны төрөл зүйл», УБ. 1959, 19-р тал
40. «Монгол хэл, түүх», № 8, Хөх хот 1958, 51-52-р тал.
41. «Өвөр Монголын зүүн орны ардын дуунууд». Хөх хот, 1959, 4-р тал
42. К. Маркс, Ф. Энгельс. Эв хамт намын тунхаг. УБ., 1947. 42-р тал.

тай боловч нөгөө талаар дотоодын феодалуудын дарлалыг давхар эсэргүүцсэн байдгийг онцлон хэлэх хэрэгтэй. Тухайлбал, өмнө дурдсан «Данаа бал», «Тогтохын дуу» зэрэгт эхлээд орон нутгийн феодалуудын эсрэг голчлон зэвсэг барин тэмцэж байснаа эцэстээ харийн түрэмгийлэгчдийг хүчтэй эсэргүүцэн тэмцсэн байдаг.

Ард түмний эрх ашгийг хамгаалж, шар, хар феодалуудын эсрэг зохиогдсон «Данаахуар»[43], «Дунсян гөөгөө»[44], «Даадай тэрэг»[45], «Уд мод»[46], «Ванли»[47], «Жанамаа», «Лам шувуудын ангаахай»[49] зэрэг олон арван дуу байдаг.

Феодалуудыг эсэргүүцсэн ард түмний тэмцлийг ардын дуунд тусгахдаа гол төлөв тэдний бодит үнэнийг нийтлэг дүрээр шоглон үзүүлсэн байна. Тэрчлэн Өвөр Монголын ард түмэн феодалуудыг анги хэмээн устгах хувьсгалт тэмцэл хараахан эхлээгүй байсан үед бодит байдлыг ард түмэнд, тэрчилэн феодалуудад хүртэл ойлгуулах гэсэн оролдлого багагүй байсан нь зарим дуунаас тодорхой. Тухайлбал, «Даадай тэрэг» хэмээх ардын дуунд:

«Харцагын жигүүр нь хугараад ирвэл
Хараацай шувуунаас юуны өөр вэ хө
Хаад ноёдын хэрэг нь буруутвал
Харц биднээс юуны ялгаа вэ хө» гэж өчүүхэн зэрэг хэргэмдээ бүү бард, үнэндээ бид адилхан хүмүүс гэсэн санааг тун чадварлаг дүрслэн ухуулан тайлбарласан байдаг.

Ийнхүү хар феодалуудыг эсэргүүцэхийн зэрэгцээ шар феодалуудын шалиг самуун явдлыг илчлэн үзүүлсэн дуу ч Өвөр Монголд цөөнгүй. «Ванли» гэдэг ардын дуунд хуучин эхнэр Сэржиймаагаа орхиж залуу охин Ванли-д санаархсан Буянхишиг гэгч ламаар тэр үеийн шар феодалуудын шалиг завхай нийтлэг дүрийг шог дууны хэлбэрээр илчлэн үзүүлжээ.

Феодалын нийгмийн үеийн лам ноёдын бодит байдлыг ийнхүү илчлэн шоолж, сайн сайхан амьдралыг хүсэн мөрөөдөхдөө ард түмэн тэдэнд дээр өгүүлсэнчлэн үнэнийг бодит байдлаар нь ойлгуулах, биеэр эсэргүүцэх, зэвсэг барин тэмцэх хүртэл олон арга хэрэглэдэг байжээ. «Уд мод» дуунд:

«...амбас ноёд нь их боловч
аминыхаа төлөө
...Түшмэд ноёд нь их боловч
Баяныхаа төлөө» гэсэн нь дарлагч, дарлагдагч хоёр ангийн хоорондын тэмцлийн туйлын зөрчлийг харуулсан том дүгнэлт мөн. Тэрчлэн дээр дурдсан «Шинэ ламын дуунд» гарч байгаа шинэ лам бол өлзийжаргал (1866—1929) гэгч бодит хүн бөгөөд Их Зуу аймгийн Үшин хошууны дугуйлангийн томоохон удирдагч байсан байна. Шинэ ламын дуу бол нийгмийн дарлалыг эсэргүүцсэн сэдэвтэй дууны нилээд сүүл үе тухайлбал XX зууны эхэн үеийн үйл явдалтай холбоотой юм. 1923/24 оноос Өлзийжаргалын тэмцэл хувьсгалт тэмцэл нэгэнт болсон бөгөөд дугуйлан нь намын байгууллагын шинжтэй болсон юм. Өлзийжаргал ядуу малчны гэрт төрж, бага наснаасаа бичиг ном сонирхон сураад улмаар Үшин хошууны вангийн ордонд бичээч болжээ. Уулаас баяд ноёдод дургүй учраас удалгүй 1910-аад онд ажлаасаа халагдан 1912 оноос Үшин хошуунд байсан 11 дугуйланг нэгтгэн удирдаж тэмцсэн байна. Уг дуунд «Шинэ ламын» удирдсан хөдөлгөөнд оролцож буй хүмүүсийн зорилгыг

43 « Өвөр Монголын залуучууд» сэтгүүл. Хөх хот, 1957, № 1, 28–29-р тал
44. ДДСХ-гийн гар бичмэлийн сан.
45. «Монгол ардын дуунууд», УБ. 1959, 108-р тал
46. «Цахар ардын дуунууд», Хөх хот, 1959, 14-р тал
47. Б. Содном. «Ардын нэгэн дууны тухай». УБ., 1959.
48. «Зүүн орны ардын дуу», Хөх хот. 1959, 157-р тал
49. «Цахар ардын дуунууд». Хөх хот, 1959. 102-р тал

«Шинэ ламын ах дүү анд нар
Цугларан цугларч нийлж байна
Шалгарсан хувьсгалын төрийг босгож

Шинэ цагийн журам ёсыг дагацгаая даа» хэмээн тодорхойлсон нь ард түмний дунд өрнөсөн дугуйлангийн хөдөлгөөн нийгмийн ба харийн дарлалыг эсэргүүцсэн тэмцэл болон өрнөж байсныг харуулж байна. Язгууртнууд Өлзийжаргалыг баривчлах гэж оролдож байсан учир тэрээр зүсээ хувилган, гэзгээ авч лам байдалтай болжээ. Иймээс нутгийнхан нь түүнийг «Шинэ лам» гэж алдаршуулж ардын дуундаа ийнхүү тусгаж байжээ. Өвөр Монголын ард түмний олон үеийн турш явуулсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь ийнхүү дотоод, гадаадын харгис хүчний эсрэг бүх нийтийг хамран өрнөж тухайн үед тэрхүү харгис хүчний чухам аль нь давамгайлж байна, түүний эсрэг илүү хүчтэй чиглэгдэж байсан нь баримтаас тодорхой байна.

Өвөр Монгол дахь үндэсний эрх чөлөөний тэмцэл нь хөрш зэргэлдээ орнуудын ард түмний хувьсгалт тэмцлийн нөлөөгөөр шинэ шатанд орж нийгмээ социалист ёсоор өөрчлөн байгуулах гэсэн эрмэлзлэлтэй болсон нь Өвөр Монголын аман зохиолд хувьсгалын сэдэвтэй ардын дуу үүсч хөгжих эх суурийг тавьжээ. Хятадад хувьсгал ялахаас өмнө Өвөр Монголд зохиогдон дуулж байсан хувьсгалт дуу нилээд байдаг. Гадаад, дотоодын дарлалыг эсэргүүцэн нийгмээ өөрчлөн байгуулахын төлөө тэмцэж байсан хувьсгалч олон түмний санаа сэтгэлийн илэрхийлэл, дайчин уриа нь болсон «Өвөр Монголын улаан туг», «Дотоод Монголыг мандуулах дуу», «Хувьсгалт нам», «Олон бага залуучууд», «Хөлөн буйрын хувьс гал»[50], «Холбоо уулын орой дээр»[51] зэрэг олон дуу энэ үеийн дуунд орно 1925 оны 8-р сард Чуулалт хаалганд болсон Дотоод Монголын Ардын Хувьсгалт Намын анхдугаар их хурлын үеэр зохиогдсон «Өвөр Монголын улаан туг» хэмээх дууг манай «Улаан туг» дууны аяар дуулж байсан нь нэн сонин. Аман зохиолын уламжлал, шинэчлэлтэй холбоотой энэ дуу:

«Догшин сүртэй улаан тугаа
Дорнот зүгт хийсгэе хө
Дотоод Монголын ахан дүү бид нар

Доромжлогч дайсныг устгая» гэж эхэлдэг бөгөөд уг дуу эрх чөлөөний сэдэвт ардын дууны санд зохих байраа эзэлсээр эдүгээ хүрч ирсэн нь хувьсгалч олон түмний дотоод сэтгэлгээ, итгэл тэмүүллийг зүй ёсоор тусгаж чадсан амьдрах чадалтай дуу болсны батлагаа мөн. Тэрчлэн 1921—1931 онд Ордост нууцаар ажиллаж байсан Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам ард түмний хувьсгалт тэмцлийг зохион байгуулах талаар багагүй ажил хийж байжээ. Тэр үед зохиогдсон «Хувьсгалт нам» хэмээх нэгэн дуунд:

«Хур ус буухгүй бол
Хуар (цэцэг) яаж дэлгэрнэ дээ
Хувьсгалт нам ирэхгүй бол

Хүн ард яаж чөлөөлөгдөнө дөө» гэсэн нь ард түмний хувьсгалт ухамсар ихэд сэргэж, өөрсдийн тэмцэлийг зоригжуулан зохион байгуулж, удирдан чиглүүлэгч их хүч болох намын ролийг зөв үнэлж байсны гэрч мөн. Үүний зэрэгцээ «Дотоод Монголыг мандуулах дуу» хэмээх өөр нэг дуунд:

50. ДДСХ-гийн гар бичмэлийн сан
51. ДДСХ-гийн гар бичмэлийн сан

«Улаан тугийг мандуулаад
Орон нутгийг хамгаалаад
Олон монгол угсаатныг
Ургаш хөгжүүлэн мандуулья
Хошуу цэргийн хооронд
Холбоо хэлхээгээ зузаатгаад
Хурц цэргийг байгуулаад
Хортон дайсныг устгая» хэмээн өгүүлсэн нь гадаад, дотоодын дайснаас нутаг орноо чөлөөлөх гэсэн ард түмний тэмцэл, намын удирдлагын доор зохион байгуулалтай болж Хятад дахь монголчуудыг эрх чөлөөний хөдөлгөөнд нэгтгэх гэсэн уриа болж байсан байна. Ийм дуунд «Монгол үндэсний тэмцэлийн дуу»[52] зохих ёсоор орно. Гадаад, дотоодын харгис уудын эсрэг олон зууны турш баатарлаг тэмцэж ирсэн өвөр монголчууд олон түмний аяндаа гарах хөдөлгөөнийг тодорхой чиглэл, зорилготой, зохион байгуулалтай болгох, тэдний хувьсгалт ухамсарыг сэргээхэд нам удирдан чиглүүлэгч гол роль гүйцэтгэнэ гэдгийг ухамсарлан ардын дуундаа тусгасаар ирсэн нь дээр дурдсан жишээнүүдээс тодорхой. 1947 оны 5-рсарын 1-нд байгуулагдсан ӨМАР-ны тухай «Таван сарын шиний нэгэн»гэдэг дууг ард түмэн энэ үед зохион дуулж байжээ. Уг дуунд:

«Таван сарын шиний нэгэнд
Монголын засаг мандав
Тэргүүлж байх хувьсгалчдын
Гэгээн туг хийсч байна
Ардын цэргийн баатарчууд
Гоминьданыг цохиж байна
Аж амьдралаа сайжруулж
Адуу малаа үржүүлье» гэжээ.

ӨМАР байгуулагдсаны дараа олон түмний хувьсгалт идэвх ихэд өрнөж байсан байна. Жишээ нь, 1947 оны 7-р сард Өвөр монголын Барга хошуунд 300-гаад залуусыг эгнээндээ нэгтгэсэн»Баргын хувьсгалт Залуучуудын Эвлэл» байгуулагдан «Холбоо уулын оройд» гэдэг залуучуудын дууг зохион дуулж байжээ. Уг дуунд:

«...Хан уулын хормойд
Хатуужилтай залуучууд цугларaад
Харанхуй нийгмийг гэгээрүүлж
Харгис феодалуудыг устгая
...Монгойн голын хөвөөнд
Монголын залуучууд цугларaад
Мунхаг харанхуйг гэгээрүүлж
Мохошгүй зоригоор тэмцэцгээе» хэмээн тэдний

хувьсгалч эрмэлзлэл, эх оронч санаа сэтгэл, ирээдүйдээ итгэх хүсэл тэмүүллийг нь тусган гаргасан байдаг. Ийнхүү харийн болоод нийгмийн удаан хугацааны дарлал мөлжлөг, эртний хятадын эзэн хаадаас эхлээд өнөөг хүрч үе дамжин уламжилж ирсэн бусад улс угсаатныг устгах хорт бодлогод байнга хэлмэгдэж ирсэн өвөр монголын ард түмэн олон зууны турш бүтээсэн соёлын их өвөө нандигнан хадгалж, хөгжүүлсээр ирсэн нь зөвхөн ардын дуугаар ч гэсэн тодорхой батлагдаж байна. Дээр жишээ болгон авсан ардын дуунаас үзэхэд гадаад, дотоодын харгис хүчний эсрэг, эрх чөлөө, аз жаргалынхаа төлөө тэмцсэн Өвөр Монголын ард түмний тэмцэл эхлээд «Данаабал» дуунд гарсны адил ганц нэгээрээ байсан бол сүүлдээ Тогтох Гаадаа нарын дуунд тусгагдсан шиг хэсэг бүлгээрээ, нийтээрээ тэмцэх

52. ДДСХ-гийн гар бичмэлийн сан

болж эцэстээ «Өвөр монголын улаан туг», «Дотоод монголыг мандуулах дуу» зэрэгт өгүүлсний адил хувьсгалт тэмцэл болон өрнөсөн нь батлагдаж байна.

Тэрчлэн Өвөр Монголын ард түмний тэмцэл эхний үед ангийн тэмцлийн шинж чанартай гарч байснаа эцэстээ үндэстний дарлалыг эсэргүүцсэн тэмцэл болон өрнөж улмаар эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олох гэсэн хувьсгалт агуулгатай болон өргөжиж байсан нь мөн нэгэн адил тод харагдаж байгаа юм. Энэ бол ард түмний хувьсгалч ухамсар бүрэлдэн тогтож, зохион байгуулалттай тэмцэх туршлагатай болж байсны түүхэн баталгаа юм.

ӨМАР байгуулагдсан 1947 оноос хойш ч гэсэн Өвөр Монголын ард түмэн их хан (хятад) үндэстний дээрэнгүй үзлийн эсрэг цуцалтгүй тэмцсээр ирсэн нь олон баримтаас тодорхой байдаг. Тухайлан нэг жишээ авч үзвэл, шинэ хятадын удирдах бүлгийн үндэстний цөөнхийг хүчээр уусгах харгис бодлогыг эсэргүүцсэн 50-иад оны нэгэн шүлэгт:

«Элс шороо бидний урагшлахыг хориглож чадахгүй
Цас мөс бидний халуун зоригийг бууруулж чадахгүй
Их хятадчилах үзлийн довтолгооныг бут цохино
Эрх чөлөөний төлөө тэмцэнэ»[53] гэж өгүүлсэн нь биеэ дааж улс төр, аж ахуйгаа хөтлөн ард түмнийхээ амьдралыг дээшлүүлэх гэсэн дэвшилт бодлогын илрэл төдийгүй, хятадчилах үзлийг ард түмэн хичнээн их эсэргүүцэн, эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байсны баталгаа мөн.

Түүхийн урт хугацаанд (1636—1947) эрх чөлөө, аз жаргал, сайн сайхныхаа төлөө цуцалтгүй баатарлаг тэмцэж ирсэн Өвөр Монголын ард түмний амьдрал, тэмцлийг тусгасан үг нь хурц, гүн утгатай, ая нь яруу, чихэнд чимэгтэй ардын дууны сангаас нийгмийн ба харийн аливаа дарлалыг эсэргүүцэн, сайн сайхан амьдралаа хүсэн мөрөөдсөн буюу тэмцэн олох гэсэн хувьсгалт агуулгатай ардын дууны талаар товч өгүүлэхэд ийм байна.

М. Зэнээ

О НАРОДНЫХ ПЕСНЯХ ВНУТРЕННЕЙ МОНГОЛИИ

Резюме

Статья посвящена научному анализу революционного содержания и национально-освободительных идей народных песен во Внутренней Монголии, возникших в период с 30-х гг. XVII века до 1947 года.

Автор по содержанию делит песни Внутренней Монголии на две группы. К первой группе относятся такие песни, как «песня о Тогтохе», песня о «Гаадане мерэне» и песня о «Данабале», которые ярче всего выражают справедливую борьбу против внутренних угнетателей и внешних колони-

53 «ӨМӨЗО-ны утга зохиолын түүх» Хөх хот, 1962

заторов за свое национальное право, которую народ Внутренней Монголии вел за вышеуказанный период и их стремление к свободе и счастью на родной земле. Так например, «песня о Тогтохе» призывает народ бороться против колонизации кочевых монголов чужеземцами.

Ко второй группе относятся такие песни, которые отражают борьбу народа за социальное освобождение. Такими песнями являются «Песня о колесницах», «песня о новом ламе», «Красный флаг Внутренней Монголии», «Революционная партия» и многие другие, в этих песнях народ призывает бороться не только за национальное, но и социальное освобождение, что является отражением наиболее прогрессивных идей песенного творчества народных масс Внутренней Монголии.

По мнению автора, содержание народных песен во Внутренней Монголии по-своему глубоко отражают особенности и идейные мотивы национально-освободительного движения народных масс на разных этапах его развития,

В заключение автор отмечаето необходимости дальнейшего комплексного изучения народного творчества Внутренней Монголии, в том числе народных песен.